



**МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН
САЙДЫН ТУШААЛ**

2020 оны 02 сарын 21 өдөр

Дугаар А/60

Улаанбаатар хот

Журам, маягт, загвар шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Төрийн албан хаагчид шагнал олгох журам”-ын 2.4, хоёрдугаар хавсралтаар батлагдсан “Засгийн газрын салбарын тэргүүний ажилтан” хүндэт тэмдгийн төрөл, түүнийг олгох эрх бүхий албан тушаалтны жагсаалтын”-ын 11, 16, 24, 37 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Зам, тээврийн салбарын албан хаагчид шагнал олгох журам”-ыг нэгдүгээр, “Засгийн газрын хүндэт тэмдэг”-ийн ерөнхий загварыг хоёрдугаар, “Зам, тээврийн хөгжлийн яамны “Хүндэт жуух бичиг”-ийн загварыг гуравдугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

2. Журмыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллахыг өмчийн хэлбэр харгалзахгүйгээр Зам, тээврийн салбар байгууллагын захирал, дарга нарт үүрэг болгосугай.

3. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар /Б.Болор-Эрдэнэ/-т үүрэг болгосугай.


4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Зам, тээврийн хөгжлийн сайдын 2017 оны “Журам шинэчлэн батлах тухай” 134 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД



Б.ЭНХ-АМГАЛАН

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2020 оны
12 дугаар сарын 21 өдрийн 150 дугаар тушаалын
нэгдүгээр хавсралт



ЗАМ, ТЭЭВРИЙН САЛБАРЫН АЛБАН ХААГЧИД ШАГНАЛ ОЛГОХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Монгол Улсын зам, тээврийн салбарыг хөгжүүлэхэд үйлсэд бодитой хувь нэмэр оруулсан, онцгой амжилт гаргасан төрийн албан хаагч, Монгол Улсын болон гадаадын иргэнийг Засгийн газрын /цаашид "салбарын шагнал" гэх/ болон Зам, тээврийн хөгжлийн яамны шагнал /цаашид "яамны шагнал" гэх/-д нэр дэвшүүлэх, шагнаж урамшуулахад энэхүү журмыг мөрдөнө.

Хоёр. Шагналын төрөл

2.1. Засгийн газрын шагнал нь дор дурдсан төрөлтэй байна.

2.1.1. "Автотээврийн тэргүүний ажилтан" хүндэт тэмдэг

2.1.2. "Хүндэт төмөр замчин" хүндэт тэмдэг

2.1.3. "Тэргүүний замчин" хүндэт тэмдэг

2.1.4. "Иргэний агаарын тээврийн тэргүүний ажилтан" хүндэт тэмдэг

2.2. Зам, тээврийн хөгжлийн яамны шагнал нь дор дурсан төрөл байна.

2.2.1. Яамны "Хүндэт жуух бичиг"

Гурав. Шагнал олгох болзол

3.1. Зам, тээврийн салбарын шагналыг яам, Засгийн газрын гэсэн дарааллаар дор дурдсан үзүүлэлтийг хангасан албан хаагч, иргэнд олгоно. Үүнд:

3.1.1. Зам, тээврийн салбарын ажил, үйлчилгээг боловсронгуй болгох дэвшилтэт техник, технологи, шилдэг арга ажиллагаа нэвтрүүлэн ажил үйлчилгээний чанар, нэр төрөл, эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлсэн тодорхой үр дүн, үр бүтээл гаргасан;

3.1.2. Салбарын мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэхэд бодитой хувь нэмэр оруулсан, салбарын хөгжилд онцгой үр дүн өгөхүйц эрдэм шинжилгээ, судалгааны шинэ нээлт, бүтээл туурвисан;

3.1.3. Зам, тээврийн салбарт онцгой амжилт гаргасан, оновчтой санаачилга гаргасан, тодорхой үр дүн бүхий бүтээлч ажил хийсэн. /энэ тохиолдолд